



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/130/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд сум

2021 он

Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч:  
Т.Ган-Өлзий

Утас: 7052-2734

Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020 Цахим хаяг:

Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Ч.Хэрлэнчимэг

Утас: 70523020

Цахим хаяг:

[Kherlenchimegch@audit.gov.mn](mailto:Kherlenchimegch@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ААН	Аж ахуй нэгж
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	12
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	14
3.4. Материаллаг байдал .....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	17
Залруулсан алдаа.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	18
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	18
4. Менежментийн захидал .....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА М.МӨНХБАЯР ТАНАА**

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

*д.д. 02.23 № 16/83*

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын жилийн тайлан, санхүүгийн тайлан ба аудитын тайланд тусгагдсанаас бусад санхүүгийн ба санхүүгийн бус мэдээлэл байхгүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг

М.Мөнхбаяр


2021.02.23

буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>57,020,962.72</b>	<b>222,876,592.30</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>15,302,295.00</b>	<b>28,190,322.00</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>15,302,295.00</b>	<b>28,190,322.00</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>15,302,295.00</b>	<b>28,190,322.00</b>
31211	Төрийн сангийн харилцах	15,302,295.00	28,190,322.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>41,718,667.72</b>	<b>194,686,270.30</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>11,891,826.20</b>	<b>25,427,047.58</b>
35130	Эм боох материал	11,891,826.20	25,427,047.58
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>29,826,841.52</b>	<b>169,259,222.72</b>
35410	Бичиг хэргийн материал	3,617,664.77	7,155,791.97
35420	Аж ахуйн материал	23,414,785.75	155,769,780.75
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	1,275,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,655,000.00	3,914,950.00
35470	Бусад хангамжийн материал	1,139,391.00	1,143,700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>479,876,282.57</b>	<b>510,250,735.55</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>479,876,282.57</b>	<b>510,250,735.55</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>448,616,563.77</b>	<b>479,169,632.07</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	260,743,585.00	263,493,585.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,461,448.25	-17,358,728.03
39203	Авто-тээврийн хэрэгсэл	145,430,100.00	165,430,100.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-117,842,492.35	-132,819,179.69
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	391,343,677.51	459,755,777.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-232,277,803.09	-293,894,386.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,202,178.48	40,434,678.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,521,233.53	-33,847,727.05
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	28,107,860.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-132,347.42
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>31,259,718.80</b>	<b>31,081,103.48</b>
39301	Программ хангамж	1,626,000.00	1,626,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-942,281.20	-1,120,896.52
39303	Бусад биет бус хөрөнгө	30,576,000.00	30,576,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>536,897,245.29</b>	<b>733,127,327.85</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>536,897,245.29</b>	<b>733,127,327.85</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>536,897,245.29</b>	<b>733,127,327.85</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>267,025,139.22</b>	<b>267,025,139.22</b>
51101	Өмч: - төрийн	267,025,139.22	267,025,139.22
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>69,624,538.49</b>	<b>265,854,621.05</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-50,250,255.88	69,624,538.49
51220	Тайлант үеийн үр дүн	119,874,794.37	196,230,082.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	200,247,567.58	200,247,567.58
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>536,897,245.29</b>	<b>733,127,327.85</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>988,034,161.39</b>	<b>1,255,591,912.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>222,879,761.39</b>	<b>213,018,212.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>222,879,761.39</b>	<b>213,018,212.00</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	207,577,466.39	194,730,185.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,567,500.00	64,503,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	137,009,966.39	130,227,085.00
120009	Бусад орлого	15,302,295.00	18,288,027.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>765,154,400.00</b>	<b>1,042,573,700.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>765,154,400.00</b>	<b>1,039,845,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	762,225,300.00	991,600,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,879,600.00	48,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,500.00	245,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>0.00</b>	<b>2,728,400.00</b>
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	0.00	2,728,400.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>868,159,367.02</b>	<b>1,059,361,829.44</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>868,159,367.02</b>	<b>1,059,361,829.44</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>609,189,891.02</b>	<b>933,162,573.06</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>427,315,984.00</b>	<b>604,188,883.87</b>
210101	Үндсэн цалин	328,311,484.00	452,511,093.39
210102	Нэмэгдэл	82,405,500.00	121,805,302.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,599,000.00	20,451,028.15
210104	Урамшуулал	0.00	9,421,460.08
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>51,863,341.00</b>	<b>73,588,759.75</b>
210201	Тэтгэврийн даатгал	35,387,696.00	50,126,034.39
210202	Тэтгэмжийн даатгал	4,164,388.00	5,897,184.09
210203	ҮОМШ өвчний даатгал	3,298,231.00	4,684,144.06
210204	Ажилгүйдлын даатгал	819,367.00	1,171,036.02
210205	Эрүүл мэндийн даатгал	8,193,659.00	11,710,361.19
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>23,452,792.00</b>	<b>23,444,710.00</b>
210301	Гэрэл цахилгаан	4,218,209.00	4,114,382.00
210302	Түлш, халаалт	15,955,923.00	15,973,269.00
210303	Цэвэр, бохир ус	1,430,660.00	1,505,759.00
210304	Байрны түрээс	1,848,000.00	1,851,300.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,696,297.00</b>	<b>44,722,339.00</b>
210401	Бичиг хэрэг	6,026,356.00	8,309,620.00
210402	Тээвэр, шатахуун	15,266,600.00	20,378,450.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	5,723,587.00	7,056,584.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,439,754.00	5,034,335.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	3,703,350.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>11,516,791.40</b>	<b>23,305,015.62</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,984,111.40	12,406,385.62
210502	Хоол, Хүнс	2,532,680.00	10,368,630.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	530,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,643,840.00</b>	<b>60,346,752.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	119,600.00	54,991,283.00
210604	Урсгал засвар	3,524,240.00	5,355,469.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>12,317,400.00</b>	<b>12,716,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	12,317,400.00	12,716,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,385,713.00</b>	<b>11,654,405.80</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,302,900.00	7,040,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,060,140.00	1,570,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,075.00	293,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	70,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,346,550.00	1,266,600.00
210807	Газрын төлбөр	15,288.00	107,016.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	866,760.00	770,129.80
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>41,997,732.62</b>	<b>79,195,507.02</b>

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	474,185.00	300,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	41,523,547.62	78,895,507.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>258,969,476.00</b>	<b>126,199,256.38</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>80,248,056.00</b>	<b>47,411,397.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	5,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	78,346,800.00	24,011,397.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,901,256.00	18,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>178,721,420.00</b>	<b>78,787,859.38</b>
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	61,720,200.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	108,138,520.00	17,067,659.38
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	70,582,900.00	0.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>119,874,794.37</b>	<b>196,230,082.56</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>119,874,794.37</b>	<b>196,230,082.56</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	851,039,595.00	1,125,364,827.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	85,885,195.00	82,791,127.00
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	85,885,195.00	82,791,127.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,582,900.00	64,503,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,582,900.00	64,503,100.00
120009	Бусад орлого	15,302,295.00	18,288,027.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	765,154,400.00	1,042,573,700.00
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	762,225,300.00	991,600,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	762,225,300.00	991,600,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,929,100.00	48,245,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,879,600.00	48,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,500.00	245,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	0.00	2,728,400.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	0.00	2,728,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	835,737,300.00	1,112,476,800.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	831,490,300.00	1,075,368,940.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	572,528,224.00	949,169,683.62
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	427,315,984.00	604,188,883.87
210101	Үндсэн цалин	328,311,484.00	452,511,093.39
210102	Нэмэгдэл	82,405,500.00	121,805,302.25
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	16,599,000.00	20,451,028.15
210104	Урамшуулал	0.00	9,421,460.08
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	51,863,341.00	73,588,759.75
210201	Тэтгэврийн даатгал	35,387,696.00	50,126,034.39
210202	Тэтгэмжийн даатгал	4,164,388.00	5,897,184.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,298,231.00	4,684,144.06
210204	Ажилгүйдлийн даатгал	819,367.00	1,171,036.02
210205	Эрүүл мэндийн даатгал	8,193,659.00	11,710,361.19
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	23,452,792.00	23,444,710.00
210301	Гэрэл, цахилгаан	4,218,209.00	4,114,382.00
210302	Түлш, халаалт	15,955,923.00	15,973,269.00
210303	Цэвэр, бохир ус	1,430,660.00	1,505,759.00
210304	Байрны түрээс	1,848,000.00	1,851,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	30,906,239.00	50,654,267.00
210401	Бичиг хэрэг	5,744,598.00	11,044,850.00
210402	Тээвэр, шатахуун	15,440,600.00	22,638,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,833,107.00	7,382,734.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,647,934.00	9,348,283.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	14,052,130.00	36,997,887.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,815,450.00	25,811,377.00
210502	Хоол, хүнс	2,236,680.00	10,656,510.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	530,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,877,700.00	135,198,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	972,600.00	128,421,750.00
210604	Урсгал засвар	3,905,100.00	6,776,550.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	12,317,400.00	12,716,200.00
210702	Дотоод албан томиллолт	12,317,400.00	12,716,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,268,453.00	12,080,676.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,302,900.00	7,040,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,060,140.00	1,570,600.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,075.00	289,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	70,000.00	70,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,396,550.00	1,397,000.00
210807	Газрын төлбөр	15,288.00	107,016.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,699,500.00	1,066,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	474,185.00	300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	474,185.00	300,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	258,962,076.00	126,199,256.38
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	80,240,656.00	47,411,397.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	5,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	78,346,800.00	24,011,397.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,893,856.00	18,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	178,721,420.00	78,787,859.38
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	61,720,200.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	108,138,520.00	17,067,659.38
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	70,582,900.00	0.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	15,302,295.00	12,888,027.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	4,247,000.00	37,107,860.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	4,247,000.00	37,107,860.00
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	4,247,000.00	37,107,860.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,247,000.00	37,107,860.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	-4,247,000.00	-37,107,860.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	15,302,295.00	12,888,027.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0.00	15,302,295.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	15,302,295.00	28,190,322.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	267,025,139.22	200,247,567.58	(50,250,255.88)	-	417,022,450.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	267,025,139.22	200,247,567.58	(50,250,255.88)	-	417,022,450.92
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	119,874,794.37	-	119,874,794.37
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	267,025,139.22	200,247,567.58	69,624,538.49	-	536,897,245.29
D01	<b>2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	267,025,139.22	200,247,567.58	69,624,538.49	-	536,897,245.29
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	267,025,139.22	200,247,567.58	69,624,538.49	-	536,897,245.29
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	196,230,082.56	-	196,230,082.56
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	267,025,139.22	200,247,567.58	265,854,621.05	-	733,127,327.85

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>15,302,295.00</b>	<b>(15,302,295.00)</b>
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>991,600,300.00</b>	<b>977,316,170.62</b>	<b>14,284,129.38</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>991,600,300.00</b>	<b>977,316,170.62</b>	<b>14,284,129.38</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>965,588,800.00</b>	<b>951,304,773.62</b>	<b>14,284,026.38</b>
2101	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>609,600,900.00</b>	<b>604,188,883.87</b>	<b>5,412,016.13</b>
210101	Үндсэн цалин	454,189,500.00	452,511,093.39	1,678,406.61
210102	Нэмэгдэл	124,119,300.00	121,805,302.25	2,313,997.75
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	20,713,000.00	20,451,028.15	261,971.85
210104	Урамшуулал	10,579,100.00	9,421,460.08	1,157,639.92
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>77,617,900.00</b>	<b>73,588,759.75</b>	<b>4,029,140.25</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,657,100.00	50,126,034.39	1,531,065.61
210202	Тэтгэмжийн даатгал	6,490,200.00	5,897,184.09	593,015.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,192,200.00	4,684,144.06	508,055.94
210204	Ажилгүйдлийн даатгал	1,298,000.00	1,171,036.02	126,963.98
210205	Эрүүл мэндийн даатгал	12,980,400.00	11,710,361.19	1,270,038.81
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>23,724,000.00</b>	<b>23,444,710.00</b>	<b>279,290.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,449,800.00	4,114,382.00	335,418.00
210302	Түлш, халаалт	15,973,300.00	15,973,269.00	31.00
210303	Цэвэр, бохир ус	1,449,600.00	1,505,759.00	(56,159.00)
210304	Байрны түрээс	1,851,300.00	1,851,300.00	-
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>49,563,900.00</b>	<b>49,484,967.00</b>	<b>78,933.00</b>
210401	Бичиг хэрэг	10,353,400.00	10,350,350.00	3,050.00
210402	Тээвэр, шатахуун	22,214,700.00	22,210,000.00	4,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,442,300.00	7,382,734.00	59,566.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,313,500.00	9,301,883.00	11,617.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>36,548,500.00</b>	<b>36,494,417.00</b>	<b>54,083.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,816,000.00	25,811,377.00	4,623.00
210502	Хоол, хүнс	10,199,500.00	10,153,040.00	46,460.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	533,000.00	530,000.00	3,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>141,929,500.00</b>	<b>141,874,160.00</b>	<b>55,340.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,000,000.00	16,975,860.00	24,140.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	118,124,400.00	118,121,750.00	2,650.00
210604	Урсгал засвар	6,805,100.00	6,776,550.00	28,550.00
2107	<b>Томилот, зочны зардал</b>	<b>15,445,000.00</b>	<b>12,716,200.00</b>	<b>2,728,800.00</b>
210702	Дотоод албан томилот	15,445,000.00	12,716,200.00	2,728,800.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,659,100.00</b>	<b>9,212,676.00</b>	<b>1,446,424.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,300,000.00	4,172,200.00	127,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,570,600.00	1,570,600.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	474,400.00	289,860.00	184,540.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	70,000.00	70,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,397,000.00	1,397,000.00	-
210807	Газрын төлбөр	107,100.00	107,016.00	84.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,200,000.00	1,066,000.00	1,134,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>500,000.00</b>	<b>300,000.00</b>	<b>200,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	500,000.00	300,000.00	200,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,011,500.00</b>	<b>26,011,397.00</b>	<b>103.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>26,011,500.00</b>	<b>26,011,397.00</b>	<b>103.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,011,500.00	24,011,397.00	103.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	-
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>991,600,300.00</b>	<b>977,316,170.62</b>	<b>14,284,129.38</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	991,600,300.00	977,316,170.62	14,284,129.38
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>28,190,322.00</b>	<b>(28,190,322.00)</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	0.00	<b>50,973,400.00</b>	<b>-50,973,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	0.00	<b>50,973,400.00</b>	<b>-50,973,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	<b>34,972,770.00</b>	<b>-34,972,770.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	<b>1,169,300.00</b>	<b>-1,169,300.00</b>
210401	Бичиг хэрэг	0.00	694,500.00	-694,500.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	428,400.00	-428,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	46,400.00	-46,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	0.00	<b>503,470.00</b>	<b>-503,470.00</b>
210502	Хоол, хүнс	0.00	503,470.00	-503,470.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.00	<b>30,432,000.00</b>	<b>-30,432,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	9,000,000.00	-9,000,000.00
210602	Тавилга	0.00	11,132,000.00	-11,132,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	10,300,000.00	-10,300,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.00	<b>2,868,000.00</b>	<b>-2,868,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	2,868,000.00	-2,868,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	<b>16,000,000.00</b>	<b>-16,000,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.00	<b>16,000,000.00</b>	<b>-16,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	16,000,000.00	-16,000,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	0.00	<b>630.00</b>	<b>-630.00</b>
<b>213303</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг</b>	0.00	<b>630.00</b>	<b>-630.00</b>
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	<b>50,973,400.00</b>	<b>-50,973,400.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	<b>50,973,400.00</b>	<b>-50,973,400.00</b>
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	0.00	2,728,400.00	-2,728,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	48,000,000.00	-48,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	245,000.00	-245,000.00

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг МХГ-ын дарга М.Мөнхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд дээд шатны байгууллагын зөвшөөрөлгүйгээр иргэн, ААНБ-аас хандив авахгүй байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 15-наас 2021 оны 02 дугаар сарын 19-ний хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Хэрлэнчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/51 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Байгууллагын эрхэм зорилгыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийг сахиулан, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх, хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх.

Мэргэжлийн хяналтын газрын стратегийн зорилтыг дараах байдлаар тодорхойлж, стратеги төлөвлөгөөнд тусгасан байна. Үүнд:

- Мэргэжлийн хяналтын талаарх хууль тогтоомж, хяналт шалгалтын бодлого, стратегийг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах;
- Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх таатай орчныг бий болгоход үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн төрийн захиргааны мэргэжлийн хяналтыг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх;
- Хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилтийг хангах, дотоод хяналтыг зохион байгуулах;
- Мэргэжлийн хяналтын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалтын стандарт, нийтлэг шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох;
- Иргэдийг эрүүл аюулгүй бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллээр хангах, хууль тогтоомжийг нийтийн хүртээл болгох;
- Байгууллага, аж ахуйн нэгжийн дотоод хяналтын эрхзүйн орчныг боловсронгуй болгох, мэргэжлийн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх;
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны шилэн дансанд дотоод аудит хийгдээгүй ба МХЕГ-ын Хууль зүй, мониторингийн хэлтсээс тус байгууллагын шилэн дансны үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж ажилладаг байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “үр нөлөөтэй” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардал болон 411,395.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,113.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон байна. Гүйцэтгэлийн үе шатанд суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал болох 1,059,361.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож, 10,593.6 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тогтоов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 196,230.1 мянган төгрөгөөр буюу 36.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	15,302.3	28,190.3	12,888.0
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	41,718.7	194,686.3	152,967.6
Үндсэн хөрөнгө	479,876.3	510,250.7	30,374.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>536,897.3</b>	<b>733,127.3</b>	<b>196,230.1</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	536,897.3	733,127.3	196,230.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>536,897.3</b>	<b>733,127.3</b>	<b>196,230.1</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 28,190.3 мянган төгрөг болж, 12,888.0 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын ахмадын санд хөрөнгө төвлөрүүлсэн хөрөнгө нь ахмадын сангаас зарцуулсан хөрөнгөөс их байгаатай холбоотой байна.

Тайлант хугацаанд үүссэн авлага байхгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 194,686.3 мянган төгрөг болж, 152,967.6 мянган төгрөгөөр өссөн нь Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын хөдөлмөр хамгааллын хэрэглэлийн нөөцийг бүрдүүлэн ажилласнаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2020 онд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 510,250.7 мянган төгрөг болж, 30,374.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд автомашин шилжүүлэн авсан, шинэ зөөврийн сууц болон ариутгалын төхөөрөмж шилжүүлэн худалдан авсан, мөн МХЕГ-аас суурин термометрийг үнэ төлбөргүйгээр шилжүүлснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн урсгал төсвийн худалдан авалтаар 37,107.8 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 82,162.1 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн хөрөнгө байхгүй ба 767.5 мянган төгрөгийн хөрөнгийг зохих зөвшөөрлийн дагуу акталж, данснаас хассан байна.

Тайлант онд өр төлбөр үүсгээгүй ба харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, баталгаажуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансанд өөрчлөлт гараагүй байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 267,557.7 мянган төгрөгөөр буюу 21.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого байна. Энэ нь МХЕГ-ын даргын 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/02 дугаартай тушаалаар байгууллагад шинээр 10 орон тоог нэмж, албан хаагчдын цалин хөлс, НДШ-ийн зардлыг санхүүжүүлэх, мөн хөдөлмөр хамгааллын хувцасны төсвийг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 191,202.4 мянган төгрөгөөр буюу 18.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, нэмэгдэл урамшил, НДШ, хоолны зардал, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авах зардал гэх мэт зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга хийсэн бичилт байхгүй.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,011,600.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,011,600.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 19,999.7 мянган төгрөгөөр бууруулж, 991,600.3 мянган төгрөгөөр баталсан байна. Шинээр барилга барих, тоног төхөөрөмж худалдан авах зорилготой хөрөнгө оруулалтын 208,468.8 мянган төгрөгийн зардлыг батлаагүй байна. Харин орон тоо нэмэгдсэн учраас цалин хөлс болон НДШ-ийн зардлыг нэмэгдүүлэн баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 991,600.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 991,600.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 991,600.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 50,973.4 мянган төгрөг, нийт 1,042,573.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,028,289.6 мянган төгрөгийг зарцуулж 14,284.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 977,316.2 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардлыг 9,441.1 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардлыг 2,728.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1,446.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэн зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь үндсэн үйл ажиллагаа арга хэмжээнд батлагдсан төсвийг дутуу зарцуулагдсантай холбоотой байна. Энэ нь тайлант онд 7 орон тоо дутуу ажилласан, коронавирусын тархалтын улмаас байгууллагын 2020 оны төлөвлөгөө болон зөвлөн туслах хяналт шалгалт 96 хувийн гүйцэтгэлтэй байсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд 69,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 64,503.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 93.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Лабораторийн шинжилгээний орлого	7,000.0	18,414.1	-11,414.1	263.1%
Ариутгалын орлого	62,000.0	46,089.0	15,911.0	74.3%
<b>Нийт дүн</b>	<b>69,000.0</b>	<b>64,503.1</b>	<b>4,496.9</b>	<b>93.5%</b>

Шинэ төрлийн коронавирус маш хурдацтай тархаж буй нөхцөлд онцгой анхаарал хандуулах зөвлөмж өгсөнтэй холбогдуулан 2020 оны 2 дугаар сарын 17-ний өдрөөс 3 дугаар сарын 26-ны өдрүүдэд Ханги хилийн боомтоор хийгддэг нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа түр зогссон. Энэ нь ариутгалын орлогын төлөвлөгөө биелэгдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,728.4 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 20,000.0 мянган төгрөг, аймгийн онцгой комиссоос 28,000.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого /тендерийн хураамж/ 245.0 мянган төгрөг, нийт 50,973.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамжийн материалд 1,169.3 мянган төгрөг, нормативт зардалд 503.5 мянган төгрөг, эд хогшил худалдан авахад 30,432.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 2,868.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэгт 16,000.0 мянган төгрөг, нийт 50,972.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 91 мэдээллээс хугацаандаа оруулсан 91 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Хугацаа хоцроосон болон шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл бүртгэгдээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн үнийн дүнгүй 2 зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	1	-	1	-	50

Улсад төвлөрүүлдэг орлогын төлөвлөгөөг биелүүлэх, энэ чиглэлээр арга хэмжээ авч ажиллах талаар өмнөх онд зөвлөмж өгсөн байна. Тайлант онд орлогын төлөвлөгөө 6.5 хувиар тасарч, уг зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна. Гэвч үндсэн үйл ажиллагааны орлого нь цар тахлын нөлөөллөөс шалтгаалж биелэгдээгүй байгаад шинжилгээ хийж, илрүүлсэн тул өмнөх онд өгсөн уг зөвлөмжид албан шаардлага өгөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 117,337.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 115,411.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,926.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант оны 1-12 дугаар саруудад нийт 115,411.9 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг олгосон байна. Цалингийн урьдчилгааг олгохдоо ажилчдаас авах авлага үүсгэсэн боловч, урьдчилгааг цалингаас суутгахдаа цалингийн өглөг дансанд бүртгэхгүйгээр цалингийн зардал дансанд тусгасан байна. Уг алдааг аудитын явцад залруулж, цалингийн өглөг дансанд бүртгэв.

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 1,926.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,926.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Тус байгууллагын лабораторийн итгэмжлэх шалгалтыг гүйцэтгэх Стандарт хэмжил зүйн газрын 3 албан хаагч тус аймагт ирсэн ба эдгээр албан хаагчдын байрласан зочид буудлын үйлчилгээний хөлсийг МХГ-аас шилжүүлсэн байна. Нэг албан хаагчийн байрны зардалд өдөрт 250.0 төгрөг, нийт 3 хоног байрласан хөлс болох 2,250.0 мянган төгрөгийг “Хур говь” зочид буудлын дансанд шилжүүлж, 1,926.0 мянган төгрөгийг тогтоосон дээд хэмжээнээс хэтрүүлэн, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Сангийн сайдын 2018 оны 301 “Зардлын дээд хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тушаалын 2-т *“...байрны зардлыг аймгийн төвд 36.0 мянган төгрөгөөр тогтоосугай”* гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 1 зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд тус байгууллагын даргын тушаалаар аймгийн Онцгой комиссын шуурхай штабын байр, авто тээврийн хэрэгслийн хяналтын цэгүүдэд албан хаагчдыг ажиллуулсан байна. Энэ хугацаанд иргэн, ААНБ-тай гэрээ байгуулан, албан хаагчдыг хоол хүнсээр хангаж ажилласан ба нийт 8,027.0 мянган төгрөгийг хоолны зардлаас зарцуулсан байна. Гэвч эдгээр албан хаагчдыг хоол хүнсээр хангасан талаар нотлох баримт байхгүй, гэрээг дүгнэн ажиллаагүй байна.

Иймд дараагийн аудитаар иргэн, ААНБ-тай хийсэн гэрээний хэрэгжилт болон гэрээг хэрхэн дүгнэсэн талаар баримт нотолгоог хянаж, шалгах асуудалд эрсдэл тооцож, шалгах нь зүйтэй байна.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### *Орлогын данстай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт: Тус байгууллагад цар тахлаас хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлмөр хамгааллын хувцас, бараа материалыг “Си Өү Эй Эл” ХХК-иас хандив, тусламжаар өгсөн байна. Гэвч хэдэн ширхэг, ямар төрлийн бараа материал авсныг нотлох баримт байхгүй, хүлээлгэн өгсөн талаар баримт үйлдээгүй байна. Иймд МХГ-ын өмч хамгаалах байнгын зөвлөл нь тус компаниас өгсөн бараа материалыг зах зээлийн үнэ ханшид үндэслэн бараа материалыг үнэлэн НББ-д тусгасан байна. Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр хүлээн авсан бараа материалын нийт үнэлгээг 18,500.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. Хандивлагч байгууллагаас өгсөн бараа материалын үнийн дүнг тогтоосон нотлох баримт байхгүй учир зөрчлийн дүнг тэг төгрөгөөр тооцов.

Тухайн байгууллага нь хандив, тусламжийг хүлээн авах болон бүртгэхдээ дээд шатны байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна.

1.2. Эрсдэл: Хандивлагч байгууллагатай ашиг, сонирхлын зөрчил үүсэх.

1.3. Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т “Төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно”, НАНБХАСЗАСЗУСТ хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т “Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна” гэж зааны дагуу дээд шатны байгууллагын зөвшөөрлийг үндэслэн иргэн, ААН-ээс хандив, тусламж авч байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			ДГА-2021/130/ТШЗ-СТА
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Аймгийн Мэргэжлийн хяналтын газар</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цалингийн урьдчилгааг суутгахдаа цалингийн өглөгийн дансанд бүртгэхгүйгээр цалингийн зардал дансанд тусгасан байна.	115,411.8	Аудитын явцад залруулсан	Дарга, нягтлан бодогч	М.Мөнхбаяр, Д.Болормаа
2	Дээд шатны байгууллагын зөвшөөрөлгүйгээр ААН-ээс бараа материал хандиваар авсан.	-	Зөвлөмж өгөх		
3	Томилолтын байрны зардлын дээд хэмжээг хэтрүүлэн, төсвийг үр ашиггүй зарцуулсан	1,926.0	Албан шаардлага		
<b>ДҮН</b>		<b>117,337.8</b>			